

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/6.22 дугаар зүйлийн 2, 3, 4 дахь хэсэг:

“2.Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад харуулсан, эсхүл хуулбарлаж өгсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/6.27 дугаар зүйл:

“6.27 дугаар зүйл.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих

1.Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авсан зорилгоос өөр зорилгоор мэдээллийг ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусад эх сурвалжаас боловсруулж, мэдээллийн эзнийг таньж, тодорхойлсон бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж болох шийдэр гаргах нөхцөл бүрдүүлсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “6.24 дүгээр зүйл,” гэсний дараа “6.27,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/13.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн “доторх орчны” гэсний дараа “болон орох, гарах хэсгийг хамруулан” гэж, мөн зүйлийн Тайлбарын “хүнийг” гэсний дараа “, “хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршил” гэж цахилгаан шат, ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөө зэргийг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “3” гэсэн дугаарыг “4” гэж, 13.10 дугаар зүйлийн гарчгийн “Хувь хүний нууцад халдах” гэснийг “Хувь хүний нууц, биометрик, генетикийн мэдээлэлд халдах” гэж, 13.11 дүгээр зүйлийн гарчгийн “Хувь хүний нууцыг задруулах” гэснийг “Хувь хүний нууц, биометрик, генетикийн мэдээллийг задруулах” гэж, 13.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13.11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “нууцыг” гэснийг “нууц, биометрик, генетикийн мэдээллийг” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өө” гэснийг “биометрик мэдээлэл /гарын хурууны хээ/-ээ” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “биеийн давхцахгүй өгөгдөл” гэснийг “биометрик мэдээлэл” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/” гэснийг “биометрик мэдээлэл /гарын хурууны хээ/” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17 дахь заалтын “биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/” гэснийг “биометрик мэдээлэл /гарын хурууны хээ/” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалтын “биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/” гэснийг “биометрик мэдээлэл /гарын хурууны хээ/-ийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.9 дэх заалтын “биеийн давхцахгүй өгөгдлийг /гар, хурууны хээ/” гэснийг “биометрик мэдээлэл /гарын хурууны хээ/” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг